



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IY байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.02.25 № 01/10 ЧАГ/САГ/2013/21/СТГА-ТӨЧГ

Төсвийн орлого болгох тухай

Үндэсний аудитын газрын 2012 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Чингисхаан олон улсын нисэх буудлын 2012 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

1. Сар бүр нэг ажилтанд 3500 төгрөгөөр тооцож цай, кофе, сахарын зардалд жилд нийт 24.3 сая төгрөг зарцуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16.3-д "үйлдвэрийн үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас эрх бүхий байгууллагаас баталсан нормативт хэмжээгээр өөртөө үлдээж захиран зарцуулах" гэснийг зөрчсөн;
2. 14 алба, хэлтсийн дарга нарт 30.3 сая төгрөгийн шатахуун зарцуулсан нь Засгийн газрын 2007 оны 349 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад заасныг зөрчсөн,
3. МИАТ ХК-д ангарын зориулалттай талбайг сард 1 м квадратын үнийг 2800 төгрөгөөр түрээслүүлдэг нь ТӨХ-ны 2007 оны 47 дугаар тогтоолын 1-р хавсралтанд заасныг зөрчиж 170.8 сая төгрөгийн орлого олох боломжийг алдсан,

Монгол улсын 2012 оны "Төрийн аудитын тухай" хуулийн 15.1.12, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 2.1.1 заалтуудыг үндэслэн  
**ТОГТООХ НЬ:**

1. Дээр дурдсан 225.4 сая төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сангийн 900000601 тоот дансанд 2013 оны 4 дүгээр сарын 25-ны дотор төвлөрүүлж, улсын төсвийн орлого болгохыг Чингисхаан олон улсын нисэх буудлын дарга Л.Бямбасүрэн, Ерөнхий нягтлан бодогч Х.Баярмаа нарт хариуцуулав.

2. Тогтоосон төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч, биелэлтийг 2013 оны 4 дүгээр сарын 25-ны дотор ҮАГ-т ирүүлэхийг Чингисхаан олон улсын нисэх буудлын дарга Л.Бямбасүрэн, Ерөнхий нягтлан бодогч Х.Баярмаа нарт хариуцуулав.

### АКТЫГ

ТОГТООСОН:

ЗӨВШӨӨРСӨН:

Үндэсний аудитын газрын

Ахлах аудитор

Бодит бүртгэл Аудит ХХК-ийн

Захирал

И.Туяа

3.Ганболд

Чингисхаан олон улсын нисэх  
буудлын дарга

Ерөнхий нягтлан бодогч

Л.Бямбасүрэн

Х.Баярмаа



*Тайлбар*

*Зоргоор тавигдсан сар бүр ажигланг олгох  
цай, сахарын (24.3 сая) төлбөрийг ИМЕТ-и дарга 2009  
онд гаргасан тушаалын дагуу жил бүр олгож байгаа.  
14 амд, эрхтэйин дарга нарт олгох шатааруу-  
ны мөнгийг мөн адил ИМЕТ-и дарга тушаал-  
ын дагуу жил бүр олгож байгаа.*